



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн
Удирдах зөвлөлийн дарга, дэд даргыг сонгох,
нарийн бичгийн даргыг томилох тухай

Дээд боловсролын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.8, БШУ-ны Сайдын 2024 оны 4 дүгээр сарын 23-ний өдрийн А/188 дугаар тушаал, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн дүрмийн 4.1, 4.3 дахь заалт, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.1, 3.3 дах заалтууд, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн хурлын тэмдэглэл, Удирдах зөвлөлийн гишүүдийн нээлттэй санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн даргаар Удирдах зөвлөлийн гишүүн М.Батгэрэлийг сонгосугай.
2. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дэд даргаар Удирдах зөвлөлийн гишүүн Д.Баттогтохыг сонгосугай.
3. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар ШУТИС-ийн Захирлын ажлын албаны дарга Н.Ганзоригийг томилон ажиллуулсугай.

ДАРГА



М.БАТГЭРЭЛ



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 02


Улаанбаатар хот

“Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн дүрэм” батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/53 дугаар тушаалын хавсралт “Дээд боловсролын сургалтын байгууллагын үлгэрчилсэн дүрэм”, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн зөвлөлийн дүрмийн 4.1.1, Удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн дүрэм”-ийг хавсралтаар баталж, 2024 оны 05 дугаар сарын 17-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.
2. Батлагдсан дүрмийг мөрдөж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Ректор (Т.Намнан), их сургуулийн бүтцийн нэгжүүдийн удирдлагуудад даалгасугай.
3. Энэхүү дүрэм батлагдсантай холбогдуулан Удирдах зөвлөлийн 2017 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 11 тоот тогтоолоор батлагдсан “ШУТИС-ийн дүрэм”-ийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



М.БАТГЭРЭЛ



Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн
Удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 17
өдрийн 02 дугаар тогтоолын хавсралт

ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургууль (цаашид ШУТИС гэх) нь ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсрол, дэд бакалавр, бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг сургалт, судалгаа, туршилт-үйлдвэрлэлийн төрийн өмчийн байгууллага байна.
- 1.2. ШУТИС-ийн удирдлага, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа, гадаад, дотоод, харилцааг Монгол Улсын Үндсэн хууль, Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай, Шинжлэх ухаан, технологийн тухай, Инновацын тухай хууль болон бусад холбогдох эрх зүйн акт, тэдгээртэй нийцүүлэн баталсан энэхүү ШУТИС-ийн дүрмээр зохицуулна.
- 1.3. ШУТИС-ийн хөгжлийн Алсын хараа:
“Дэлхийд үнэлэгдэх оюуны үнэ цэнийг бүтээнэ.”
- 1.4. ШУТИС-ийн Эрхэм зорилго:
“Эх орны хөгжлийн гарцыг тодорхойлох хүн-байгальд ээлтэй шинжлэх ухаан, технологийн мэдлэг, инновацийг бүтээх авьяас чадварын төвлөрөл байна.”
- 1.5. ШУТИС-ийн үнэт зүйлс: ШУТИС-ийн хамт олон (багш, судлаач, ажилтан, суралцагч, төгсөгч) бид эрхэм зорилгоо биелүүлэхийн тулд өөр өөрийн үүрэгт ажлаа гүйцэтгэхдээ, бүх төрлийн харилцаанд үүсэх дараах үнэт зүйлсийг баримтлан, дагаж мөрдөнө.
ШУТИС (Шилдэг гүйцэтгэл, Уламжлал, Тэмүүлэл, Инновац, Сайн-хүмүүнлэг засаглал) -лаг байна.
- 1.6. ШУТИС-ийн үйл ажиллагааны зорилго нь нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, дэвшилтэт шинэ санаа, судалгаа, инновацыг хөгжүүлэх, бүтээлчээр ашиглах, олон соёлын орчинд ажиллаж, амьдрах чадвартай, ёс суртахуунтай мэргэжилтэн, судлаачдыг бэлтгэх, шинэ мэдлэг буй болгох, нийгмийн түншлэл, мэдээлэл, мэдлэг, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаанд тулгуурлан судалгаа, инновацын ажлын үр дүнг бизнес, үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд оршино.
- 1.7. ШУТИС-ийн оршин байгаа хаяг: Монгол Улсын, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу 34, Шинжлэх ухаан, технологийн их сургууль.
- 1.8. ШУТИС-ийн оноосон нэрийг англи хэлээр “Mongolian University of Science and Technology” гэх ба товчилсон нэр нь “MUST”, цахим хуудасны нэр нь “www.must.edu.mn” байна.
- 1.9. “Шинжлэх ухаан, технологийн их сургууль” нэрийн албан ёсны товчилсон нэр нь “ШУТИС” бөгөөд энэхүү товчлол нь Монгол улсын Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулиар тус их сургуулийн эзэмших барааны тэмдгээр баталгаажсан байна.
- 1.10. ШУТИС нь албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн туг, ёслолын хувцас, бэлгэдэлтэй байна.
- 1.11. ШУТИС-ийн харьяаллын байгууллагууд энэхүү “ШУТИС-ийн дүрэм” болон бусад холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн өөрийн дүрмийг баталж мөрдөнө.

Хоёр. ШУТИС-ийн үйл ажиллагааны үндсэн чиглэл

- 2.1. ШУТИС нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:



Шинжлэх ухаан технологийн их сургуулийн
Удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 17
өдрийн 05 дугаар тогтоолын хавсралт

- 2.1.1. бүх шатны боловсрол, шинжлэх ухаан, технологи, инновац, сургуулийн үйл ажиллагааны чиглэлээр эрх бүхий этгээдийн баталсан бодлого, стратеги төлөвлөгөө, дүрэм, журмыг чанартай хэрэгжүүлэх, тайлагнах;
 - 2.1.2. сургуулийн дотоод үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журмыг батлан хэрэгжүүлэх;
 - 2.1.3. бүх шатны боловсролын сургалт, түр сургалтын хөтөлбөр, агуулга, арга, хэлбэр, судалгаа, туршилтын ажлын зорилт, чиглэлийг тодорхойлж, чанартай хэрэгжүүлэх;
 - 2.1.4. зөвлөх үйлчилгээ, эрдэм шинжилгээ, судалгаа, хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх, оролцох;
 - 2.1.5. бүх шатны боловсролын сургалтын элсэлт, төгсөлтийн үйл ажиллагааг зохих журмын дагуу зохион байгуулах;
 - 2.1.6. тусгай хэрэгцээ шаардлагатай суралцагчийг дэмжих хөтөлбөр баталж, шаардагдах орчин нөхцөлийг бүрдүүлэх;
 - 2.1.7. багш, эрдэм шинжилгээний ажилтан бэлтгэх, давтан сургах, үйл ажиллагаандаа нийцүүлэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, технологийн судалгаа хийх;
 - 2.1.8. их сургуулийн үйл ажиллагаа, сургалтад цахим технологи нэвтрүүлэх;
 - 2.1.9. гадаад, дотоодын боловсрол, шинжлэх ухааны байгууллага, шинжлэх ухааны парк, бусад этгээдтэй өөрийн эрх хэмжээний асуудлаар гэрээ, хэлэлцээр байгуулах, хамтран ажиллах;
 - 2.1.10. багш, ажилтан, суралцагчийг соён гэгээрүүлэх, олон нийтийн болон хүмүүнлэгийн чиглэлийн үйл ажиллагааг дэмжих хөтөлбөр батлан хэрэгжүүлэх;
 - 2.1.11. багш, ажилтан, суралцагчийн эрүүл мэндийг хамгаалах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх болон нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх хөтөлбөр баталж, хэрэгжүүлэх;
 - 2.1.12. багш, ажилтны эрүүл мэндийг дэмжих зорилгоор жил бүр эрүүл мэндийн үзлэг оношилгоонд хамруулах арга хэмжээг зохион байгуулах;
 - 2.1.13. амжилттай суралцаж, олон нийтийн болон хүмүүнлэгийн бүтээлч ажил гүйцэтгэсэн суралцагчид тэтгэлэг олгох, төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх;
 - 2.1.14. аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан сургалт, эрдэм шинжилгээний ажилд амжилт гаргасан суралцагчид нэрэмжит тэтгэлэг олгох, сургалтын төлбөр, амьжиргааны зардлын болон эрдэм шинжилгээ, судалгааны ажлын дэмжлэг үзүүлэх;
 - 2.1.15. багшаар ажиллах журам, багшийн мэргэжлийн хөгжлийг хангах, үйлдвэрт дадлагажуулах, багш, ажилтны ажлын гүйцэтгэлийг дүгнэх журмыг тус тус баталж, хэрэгжүүлэх;
 - 2.1.16. сургууль жендерийн мэдрэмжтэй, хүний эрхийг эрхэмлэсэн, ялгаатай хэрэгцээтэй суралцагчийн хэрэгцээ, шаардлагыг хангасан сургалт, судалгаа, дотуур байрны орчныг бүрдүүлэх;
 - 2.1.17. эрдэм шинжилгээ, инновацын үйл ажиллагаа эрхэлж, гарсан үр дүнг үйлдвэрлэл, хэрэглээнд нэвтрүүлэх;
 - 2.1.18. статистикийн болон бусад шаардлагатай мэдээллийг тогтоосон хугацаанд нь үнэн зөв гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэх;
 - 2.1.19. хуульд заагдсан бусад чиг, үүрэг.
- 2.2. ШУТИС-ийн үйл ажиллагаатай холбоотой хуулиар хориглоогүй аливаа мэдээллээр суралцагч, багш, ажилтныг хангах, холбогдох мэдээллийг ил тод байлгах зохион байгуулалтын арга хэмжээ авах, их сургуулийн үйл ажиллагаа, үр дүнгийн талаар нээлттэй мэдээлэх тогтолцоог бүрдүүлнэ.



Шинжлэх ухаан технологийн их сургуулийн
Удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 17
өдрийн 02 дугаар тогтоолын хавсралт

- 2.3. Багш, ажилтан, суралцагч интернэтийн орчинд ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлж, их сургуулийн цахим хуудастай байна. Их сургуулийн дотоод үйл ажиллагаандаа зориулан интернэт (дотоод сүлжээ)-тэй байна.
- 2.4. Багш, ажилтан, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас сургуулийн үйл ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэгжилт, багш, удирдах ажилтны мэргэжлийн чадавх, ёс зүй, иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхлыг зөрчсөн хэмээн үзсэн гомдол, бусад асуудлаар хандсан өргөдөл, санал хүсэлтийг хууль тогтоомжид заасны дагуу хүлээн авч судлан хариу өгнө.
- 2.5. ШУТИС нь Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн хөдөлмөрийн харилцаа, дотоод үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан хөдөлмөрийн дотоод журамтай байх бөгөөд түүнийг холбогдох журмын дагуу баталж мөрдөнө.

Гурав. ШУТИС-ийн бүтэц, зохион байгуулалт

- 3.1. ШУТИС-ийн зохион байгуулалтын үндсэн нэгж нь тэнхим, лаборатори байна.
 - 3.1.1. Тэнхим нь шинжлэх ухааны тодорхой салбараар төрөлжсөн, мэргэжлийн болон техникийн боловсрол, дэд бакалавр, бакалавр, магистр, докторын хөтөлбөрүүдийг эрхлэн хэрэгжүүлдэг, их сургуулийн хэмжээнд сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагааг эрхлэх нэгж байна.
 - 3.1.2. Лаборатори нь сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, туршилтын үйлчилгээ явуулахад зориулсан тоног төхөөрөмж, хүний нөөц бүхий сургалт, судалгааны орчин бүхий нэгж байна.
- 3.2. Тэнхим, лабораторийн бүтэц, зохион байгуулалт, ажиллах зарчим, үйл ажиллагааг холбогдох журмаар зохицуулна.
- 3.3. ШУТИС нь харьяалалдаа бүрэлдэхүүн, салбар, харьяа сургууль (ахисан түвшний сургууль, дээд сургууль, коллеж, технологийн коллеж (коосен), политехник коллеж, мэргэжлийн боловсролын сургууль, ахлах сургууль), судалгааны лаборатори, төв, хүрээлэн, сургалт-үйлдвэрлэлийн дадлагын баазтай байна. ШУТИС нь эдгээр бүтцийн нэгжийг гадаад, дотоодын байгууллагуудтай хамтран зохион байгуулж, ажиллуулж болно.
- 3.4. ШУТИС нь оюуны болон технологийн нөөцийг ашиглах, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын ололтыг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх зорилгоор өөрийн үндсэн бүтцэд эрдэм шинжилгээний хүрээлэн, сургалт, судалгааны, бизнес инкубатор, технологи дамжуулах төв, гарааны компани, гарааны компанид дэмжлэг үзүүлэх зорилго бүхий зөвлөх компани, шинжлэх ухааны парк, технологи, инновацийн кластер, туршилт үйлдвэрлэлийн болон эдгээртэй адилтгах нэгжийг бие даан, эсхүл хамтран байгуулж болно.
- 3.5. ШУТИС-ийн бүрэлдэхүүн, салбар болон харьяаллын байгууллага нь үйл ажиллагаагаа холбогдох хууль тогтоомж, их сургуулийн болон харьяаллын байгууллагын дүрэм, бусад батлагдсан дүрэм, журмын хүрээнд явуулна.
- 3.6. ШУТИС-ийн харьяаллын байгууллага нь бие даасан хуулийн этгээд байх бөгөөд зохих журмын дагуу үйлдсэн албан бичгийн хэвлэмэл хуудас, тамга, тэмдэг хэрэглэж, өөрийн бэлгэдэлтэй байж болно.
- 3.7. Профессорын баг нь эрдэм шинжилгээний тодорхой чиглэлээр дагнасан болон хамтарсан судалгаанд суурилсан, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх их сургуулийн нэгж байна.
- 3.8. ШУТИС-ийн бүтэц, зохион байгуулалттай холбоотой асуудлыг дор дурдсанаар шийдвэрлэнэ. Үүнд:
 - 3.8.1. ШУТИС-ийн салбар, харьяаллын байгууллага байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Шинжлэх ухаан технологийн хууль болон бусад холбогдох хуульд заасны дагуу эрх бүхий байгууллага шийдвэрлэнэ.



Шинжлэх ухаан технологийн их сургуулийн
Удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 17
өдрийн 12 дугаар тогтоолын хавсралт

- 3.8.2. ШУТИС-ийн Захиргааны бүтэц, зохион байгуулалт, бүрэлдэхүүн, салбар байгууллага, гарааны компани байгуулах, өөрчлөх татан буулгах асуудлыг Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Шинжлэх ухаан технологийн хууль болон бусад холбогдох хууль, дүрэм, журамд нийцүүлэн ШУТИС-ийн Удирдах зөвлөл шийдвэрлэнэ.
- 3.8.3. ШУТИС-ийн тэнхим, лаборатори, профессорын баг зэрэг сургалт, судалгааны нэгжүүдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг ШУТИС-ийн Эрдмийн зөвлөл шийдвэрлэнэ.
- 3.9. ШУТИС-ийн бүтцийн зохион байгуулалтын нэгж, бүрэлдэхүүн, салбар, харьяа сургууль, коллеж, политехник коллеж, технологийн коллеж (коосен), мэргэжлийн болон техникийн боловсролын сургууль, ахлах сургуулийн хичээлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөөг Ректорын зөвлөл, харьяа сургуулийн Захирлын зөвлөлөөр хэлэлцүүлэн, холбогдох эрх бүхий албан тушаалтнаар батлуулна. Хөтөлбөр, төлөвлөгөөнд дараах асуудлыг тусган хэрэгжүүлнэ:
 - ✓ Сургуулийн хөгжлийн зорилт;
 - ✓ Сургалт эрдэм шинжилгээний үйл ажиллагаа;
 - ✓ Хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаа;
 - ✓ Боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар, үр дүн;
 - ✓ Суралцагчийн хөгжил, төлөвшил, хамгаалал;
 - ✓ Мэдээлэл харилцаа, технологийн хөгжил;
 - ✓ Хамтын ажиллагаа, нийгмийн түншлэл, олон нийтийн оролцоо;
 - ✓ Хөрөнгө, санхүүгийн удирдлага, төлөвлөлт.
- 3.10. ШУТИС-ийн бүрэлдэхүүн, салбар сургууль, харьяаллын байгууллага нь үйл ажиллагааны, санхүүгийн болон гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг Ректорын зөвлөл, тухайн хамт олон, өөрийн удирдлагын байгууллагад тайлагнан, үнэлүүлнэ.

Дөрөв.ШУТИС-ийн удирдлага

- 4.1. ШУТИС-ийн өөрийн удирдлагыг Удирдах зөвлөл, мэргэжил, арга зүйн удирдлагыг Эрдмийн зөвлөл, Хөтөлбөрийн хороо, Сургалт арга зүйн зөвлөл тус тус хэрэгжүүлнэ.
- 4.2. ШУТИС-ийн гүйцэтгэх удирдлагыг Ректор, ШУТИС-ийн харьяаллын байгууллагын гүйцэтгэх удирдлагыг тухайн байгууллагын Захирал (цаашид Ректор, Захирлыг хамтад нь "гүйцэтгэх удирдлага" гэх) хэрэгжүүлнэ.
- 4.3. Удирдах зөвлөл нь Дээд боловсролын тухай хуульд заасны дагуу байгуулагдаж, үйл ажиллагаагаа ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн дүрмээр зохицуулна. Дүрмийг Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж батална.
- 4.4. ШУТИС-ийн Эрдмийн зөвлөл болон Хөтөлбөрийн хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг Ректорын тушаалаар батална.
- 4.5. Эрдмийн зөвлөл нь сургалт, эрдэм шинжилгээний бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл байна.
- 4.6. ШУТИС-ийн Эрдмийн зөвлөл нь доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:
 - 4.6.1. сургалт, судалгааны чиглэлийг тогтоох, хэрэгжилтийн үр дүнг хэлэлцэх, дүгнэлт гаргах;
 - 4.6.2. дэд профессор, профессор, хүндэт цол олгох;
 - 4.6.3. судалгааны төсөл болон ахисан түвшний сургалт судалгааны үр дүнг хэлэлцэх, дүгнэх.
- 4.7. Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдсон бусад харилцааг ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулах журмаар зохицуулна.
- 4.8. ШУТИС-ийн Ректор нь Монгол улсын хууль, тогтоомж, энэхүү дүрэм, Удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээний дагуу ШУТИС-ийн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлнэ.
- 4.9. ШУТИС-ийн Ректор нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:



Шинжлэх ухаан технологийн их сургуулийн
Удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 17
өдрийн 02 дугаар тогтоолын хавсралт

- 4.9.1. их сургуулийн улсын хөгжлийн бодлоготой уялдуулан хөгжүүлэх стратеги төлөвлөгөө, чиглэл, хөтөлбөрийг санаачлан Удирдах зөвлөлөөр батлуулж, хэрэгжилтийг хангах;
 - 4.9.2. ШУТИС-ийн бүтэц, зохион байгуулалтын саналыг боловсруулан Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх;
 - 4.9.3. их сургуулийн бүтцийн үндсэн нэгжүүдийг хэвийн тогтвортой ажиллах нэгдсэн зохицуулалт, удирдлагаар хангах, үр дүнг хариуцах;
 - 4.9.4. гадаад, дотоод хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх, хамтарсан сургалт, хөтөлбөр, эрдэм шинжилгээ, судалгааны төсөл хэрэгжүүлэх асуудлаар гэрээ, хэлэлцээр байгуулах, хэрэгжилтийг хангах;
 - 4.9.5. байгууллагын стратеги төлөвлөгөөний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, зорилтот түвшний хэрэгжилтийн чанар, үр дүнг бүрэн хариуцах;
 - 4.9.6. санхүүжилт, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бүрдүүлж, санхүү, төсвийг үр дүнтэй төлөвлөж зарцуулах;
 - 4.9.7. их сургуулийн хөгжлийг дэмжихэд үр нөлөөтэй, хөгжихүйн болон чадахуйн /мерит/ зарчмыг хангасан засаглал, менежментийн тогтолцоог бүрдүүлж, хэрэгжүүлэх;
 - 4.9.8. хүний нөөцийг чадавхжуулах, өндөр мэдлэг ур чадвартай мэргэжилтнийг татан ажиллуулах нөхцөлийг бүрдүүлсэн хүний нөөцийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлж, багш, ажилтны нийгмийн баталгааг хангах;
 - 4.9.9. их сургуулийн чанарын удирдлагын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
 - 4.9.10. багш, судлаач, эрдэм шинжилгээний ажилтан болон бусад ажилтны орон тоо, цалингийн сүлжээг батлах;
 - 4.9.11. багш, ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтыг батлах;
 - 4.9.12. хүний нөөцийн сонгон шалгаруулалтыг чадахуйн /мерит/ болон хөгжихүйн зарчимд үндэслэн явуулж, томилох, чөлөөлөх, хөдөлмөрийн гэрээ байгуулах, биелэлтийг дүгнэх, цуцлах, чөлөө олгох, сахилгын шийтгэл ногдуулах, шагнал урамшил олгох, тодорхойлох;
 - 4.9.13. тодорхой албан тушаалтнуудтай жил бүр үр дүнгийн гэрээ байгуулах, тайланг хэлэлцүүлэх, үнэлэлт дүгнэлт өгөх;
 - 4.9.14. харьяаллын байгууллагын гүйцэтгэх удирдлага албан үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиргааны шийтгэл оногдуулах саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэн шийдвэрлүүлэх;
 - 4.9.15. холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн ШУТИС-д мөрдөх дүрэм, журмуудыг батлах, мөрдүүлэх;
 - 4.9.16. албан тушаалын бүрэн эрхийнхээ хүрээнд хамаарах асуудлаар хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргах;
 - 4.9.17. үйл ажиллагааны үр дүнгийн талаар хамт олон, Эрдмийн зөвлөл, Удирдах зөвлөл, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах;
 - 4.9.18. зарим эрх үүргээ түр хугацаагаар холбогдох албан тушаалтанд шилжүүлэх, итгэмжлэх;
 - 4.9.19. ШУТИС-ийн Эрдмийн зөвлөл, Ректорын зөвлөлийн бүрэлдэхүүнийг хянан батлах;
 - 4.9.20. ШУТИС-ийн Эрдмийн зөвлөл, Ректорын зөвлөлийг удирдах;
 - 4.9.21. тодорхой асуудлаар ажлын хэсэг байгуулах;
 - 4.9.22. удирдах зөвлөлийг хуралдуулах саналыг Удирдах зөвлөлийн даргад тавих;
 - 4.9.23. хууль тогтоомжид заасан бусад эрхийг эдэлж, үүргийг биелүүлэх.
- 4.10. ШУТИС-ийн Ректор нь эрхэлсэн ажил, үйл ажиллагаагаа үр нөлөөтэй, тасралтгүй, хэвийн жигд явуулах орчин нөхцөл бүрдүүлэх, бодлогын хэрэгжилтийг хангах зорилго бүхий ажлын алба, захиргааны газар, алба, нэгжүүдтэй байна. Эдгээрийн чиг үүрэг, орон тоог Ректор батална.
 - 4.11. Хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжтэй байна.



Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн
Удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 17
өдрийн 02 дугаар тогтоолын хавсралт

- 4.12. ШУТИС-ийн Ректор нь албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ улс төр, эдийн засаг, шашны аливаа нөлөөлөлд орохгүй, багш, ажилчид, суралцагчдын эрх ашгийг эрхэмлэн ажиллана.
- 4.13. ШУТИС нь тодорхой чиг үүрэг, үйл ажиллагаа эрхэлсэн проректоруудтай байна. Проректорууд нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний захиргааны нэгжүүдийн өдөр тутмын ажлыг шууд удирдлагаар хангаж ажиллана.
- 4.14. Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалд тавигдах шаардлагыг үндэслэн ШУТИС-ийн багш, ажилтнаас проректорын албан тушаалд 5 жилийн хугацаагаар Ректорын тушаалаар томилно.
- 4.15. ШУТИС-ийн Ректор түр хугацаагаар эзгүй байх үедээ өөрийн албан үүргийг аль нэг проректорт орлуулан гүйцэтгүүлнэ.
- 4.16. ШУТИС-ийн удирдах албан тушаалтны албан үүргийг түр орлон гүйцэтгэх, хавсран ажиллуулах асуудлыг журмаар зохицуулна.
- 4.17. ШУТИС-ийн харьяа мэргэжлийн боловсролын ахлах сургууль, политехник коллежийн захирлыг Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 24.1.6-д заасны дагуу томилж, чөлөөлнө. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 27.2.2-д заасан шаардлагыг ШУТИС-ийн харьяа политехник коллежийн хувьд их сургуульд ажилласан туршлагыг дүйцүүлэн тооцно.
- 4.18. ШУТИС-ийн харьяа ерөнхий боловсролын сургуулийн захирлыг Боловсролын ерөнхий хуулийн 28.6-д заасны дагуу томилж, чөлөөлнө.
- 4.19. Энэхүү дүрмийн 4.17, 4.18-д заасан харьяаллын байгууллагын захирал, эрхлэгч болон ШУТИС-ийн харьяаллын бусад байгууллагын (дээд сургууль, коллеж, технологийн коллеж (коосен), хүрээлэн болон бусад) гүйцэтгэх удирдлагыг томилох, чөлөөлөхөд ШУТИС-ийн Ректороос холбогдох байгууллагад санал хүргүүлэн зөвшилцөж, шийдвэрлүүлнэ.
- 4.20. Хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтын холбогдох журмыг баримтлан явуулсан сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирлыг ШУТИС-ийн Ректор томилж, чөлөөлнө.
- 4.21. ШУТИС-ийн Ректорын зөвлөл нь ШУТИС-ийн хамтын удирдлагын зарчмыг хэрэгжүүлэн захиргааны удирдлагаар хангах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэгтэй ажиллана.
- 4.22. ШУТИС-ийн Ректорын зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам, дэгийг Ректорын тушаалаар батална. Ректорын зөвлөлийн бүрэлдэхүүнд ШУТИС-ийн Ректор, проректор, бүрэлдэхүүн, салбар сургуулийн гүйцэтгэх удирдлага, харьяаллын байгууллагын гүйцэтгэх удирдлага, тодорхой чиг үүрэг бүхий захиргааны зарим нэгжийн удирдлага ажиллана.
- 4.23. ШУТИС-ийн Ректорын зөвлөл нь дараах чиг үүрэгтэй ажиллана:
 - 4.23.1. ШУТИС-ийн үйл ажиллагаа, хөгжлийн талаар бодлого, хөтөлбөрийг хэлэлцэх;
 - 4.23.2. үйл ажиллагааг зохицуулах журам, дэг, заавруудыг хэлэлцэх, батлах, нэмэлт өөрчлөлт оруулах, хэрэгжилтэд хяналт тавих;
 - 4.23.3. ШУТИС-ийн Удирдах зөвлөл, Эрдмийн зөвлөлөөс гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих ;
 - 4.23.4. ШУТИС-ийн төвлөрсөн санг бүрдүүлэх, хөрөнгө оруулалт, төсвийн зарцуулалтын асуудлыг хэлэлцэх;
 - 4.23.5. мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрийг хэлэлцэх;
 - 4.23.6. ШУТИС-ийн Удирдах зөвлөл, Эрдмийн зөвлөл болон төрийн захиргааны дээд байгууллагад тавих, хэлэлцүүлэх аливаа асуудлыг хэлэлцэх;
 - 4.23.7. хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, хүний нөөцтэй холбоотой бусад асуудлыг хэлэлцэх;
 - 4.23.8. байгууллагын, бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааны болон гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан, хяналт, шалгалт, аудитын тайланг хэлэлцэх, холбогдох дүгнэлт, шийдвэрийг гаргах;



Шинжлэх ухаан технологийн их сургуулийн
Удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 17
өдрийн 02 дугаар тогтоолын хавсралт

- 4.24. ШУТИС-ийн Ректор нь бүрэн эрхээ хэрэгжүүлэх, их сургуулийн үйл ажиллагааг тасралтгүй, жигд, үр дүнтэй удирдан чиглүүлэх, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд санал, зөвлөгөө авч, их сургуулийн удирдлагын шийдвэрийг үндэслэлтэй, шуурхай гаргах нөхцөлийг бүрдүүлэн, тодорхой асуудлаар хамтын шийдвэр гаргах зорилгоор ШУТИС-ийн Захиргааны зөвлөлийг байгуулан ажиллуулна.
- 4.25. ШУТИС-ийн Захиргааны зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагааны удирдамжийг Ректорын тушаалаар батална.

Тав. ШУТИС-ийн бүрэлдэхүүн, салбар, харьяаллын байгууллагын бүтэц, зохион байгуулалт

- 5.1. ШУТИС-ийн харьяа мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж, коллеж, технологийн коллеж (коосен), дээд сургуулийн өөрийн удирдлагыг тухайн байгууллагын Удирдах зөвлөл хэрэгжүүлнэ.
- 5.2. ШУТИС-ийн харьяаллын байгууллагын мэргэжил, арга зүйн удирдлагыг холбогдох хууль, тогтоомжид заагдсан эрх бүхий нэгж (Эрдмийн зөвлөл, Сургалт, арга зүйн зөвлөл, Хүрээлэнгийн эрдмийн зөвлөл) хэрэгжүүлнэ.
- 5.3. ШУТИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуулийн өөрийн удирдлага нь Сургуулийн зөвлөл байна.
- 5.4. ШУТИС-ийн харьяаллын байгууллагын дүрэм, бүтэц, зохион байгуулалтыг холбогдох хууль, тогтоомжид заагдсан эрх бүхий нэгж (Удирдах зөвлөл, Сургуулийн зөвлөл, Хүрээлэнгийн эрдмийн зөвлөл) батална.
- 5.5. ШУТИС-ийн бүрэлдэхүүн, салбар, харьяа сургуулийн мэргэжлийн удирдлагыг тухайн сургуулийн Эрдмийн зөвлөл, захиргааны удирдлагыг тухайн сургуулийн Захирлын зөвлөл тус тус хэрэгжүүлнэ.
- 5.6. ШУТИС-ийн бүрэлдэхүүн, салбар, харьяа сургуулийн Эрдмийн зөвлөл нь ШУТИС-ийн бодлого, хөтөлбөрийн хүрээнд тухайн сургуулийн сургалт, судалгааны чиглэлийг тогтоох, хэрэгжилтийн үр дүнг хэлэлцэх, судалгааны төсөл болон ахисан түвшний сургалт судалгааны үр дүнг хэлэлцэх, дүгнэх, сургалт, судалгаа, инновацын үйл ажиллагааг боловсронгуй болгох, хөгжүүлэх, түүний үр дүнг хэлэлцэж санал, дүгнэлт зөвлөмж гаргах чиг үүрэгтэй ажиллана.
- 5.7. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн Эрдмийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг ШУТИС-ийн Ректорын тушаалаар, Захирлын зөвлөлийн бүрэлдэхүүнийг тухайн бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирлын тушаалаар батална.
- 5.8. ШУТИС-ийн бүрэлдэхүүн, салбар, харьяа сургуулийн Эрдмийн зөвлөлийн дарга нь тухайн сургуулийн захирал, нарийн бичгийн дарга нь тухайн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, эсвэл холбогдох нэгжийн удирдлага байна.
- 5.9. ШУТИС-ийн бүрэлдэхүүн, салбар, харьяа сургуулийн Захирлын зөвлөл нь сургуулийн хөгжлийн бодлого, жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, холбогдох шийдвэр гаргах, захиргааны шуурхай удирдлагыг хангахад дэмжлэг үзүүлэх, ШУТИС-ийн Ректорын тушаал, Эрдмийн зөвлөл, Ректорын зөвлөл, Удирдах зөвлөлийн хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
- 5.10. Хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтын холбогдох журмыг үндэслэн бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирлыг Ректор томилно.
- 5.11. Бүрэлдэхүүн, салбар, харьяа сургуулийн Захирал нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
5.11.1. ШУТИС-ийн нэгдсэн бодлого, стратеги төлөвлөгөөний хүрээнд тухайн сургуулийг хөгжүүлэх бодлого, хөтөлбөр боловсруулах, хэрэгжилтийг хангах, тайлагнах, сургуулийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;



Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн
Удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 17
өдрийн 17 дугаар тогтоолын хавсралт

- 5.11.2. ШУТИС-ийн Ректор, холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон, шилжүүлсэн эрх, батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагааг явуулах, шийдвэр гаргах.
- 5.11.3. ШУТИС-ийн Ректор, бусад эрх бүхий этгээдийн баталсан албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүргийг хэрэгжүүлэх;
- 5.11.4. ШУТИС-ийн харьяаллын байгууллагын дүрэмд заагдсан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;
- 5.12. Сургалтын бус, эрдэм шинжилгээ, судалгаа инновац болон бусад үйл ажиллагаа явуулдаг ШУТИС-ийн харьяаллын байгууллагын үйл ажиллагаа нь тухайн байгууллагын дүрмээр зохицуулагдана.

Зургаа. ШУТИС-ийн сургалт, судалгааны үйл ажиллагаа

- 6.1. ШУТИС-ийн хэмжээнд үйлчлэх сургалт, судалгааны үйл ажиллагааг зохицуулах журмыг Ректор батлан, бүрэлдэхүүн, салбар, харьяа сургууль, харьяа хүрээлэн нийтээр мөрдөн ажиллана.
- 6.2. Тухайн харьяа сургууль болон хүрээлэнд үйлчлэх сургалт, судалгааны үйл ажиллагааг зохицуулах тусгайлсан журмыг холбогдох проректортой зөвшилцсөний үндсэн дээр боловсруулан хэлэлцүүлж, гүйцэтгэх удирдлага нь баталж болно.
- 6.3. ШУТИС нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон сургалт эрхлэх тусгай болон энгийн зөвшөөрлийн дагуу сургалтыг зохион байгуулна.
- 6.4. Сургалтын үйл ажиллагааг Дээд боловсролын тухай хуулийн 19 дүгээр зүйл, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу зохион байгуулна.
- 6.5. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Дээд боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйл, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6 дугаар зүйл болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан холбогдох дүрэм, журмыг баримтална.
- 6.6. Сургалтын үйл ажиллагааг сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, хичээлийн хуваарийн дагуу зохион байгуулна.
- 6.7. Хөтөлбөрийн хороо, эсхүл Сургалт арга зүйн зөвлөл нь сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, хичээлийн хуваарь, дадлагын хөтөлбөр, дүрмийг боловсруулан сургуулийн гүйцэтгэх удирдлагаар батлуулна.
- 6.8. Суралцагч элсүүлэх үйл ажиллагааг Дээд боловсролын тухай хуулийн 18 дугаар зүйл, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 12 дугаар зүйл, Боловсролын ерөнхий хуулийн 26.1.22-т заасан журам, бусад холбогдох журмыг баримтлан зохион байгуулна.
- 6.9. ШУТИС нь төгсөгчдөдөө боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу диплом олгоно.
- 6.10. Их сургуулийн хэмжээнд судалгааны үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ Дээд боловсролын тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль болон холбогдох хууль, тогтоомж, эрх зүйн актыг баримталж ажиллана.
- 6.11. Их сургуулийн судалгааны тэргүүлэх чиглэлээр судалгааны ажлыг дэмжиж тухайн сургуулийн судалгааны баг, багш, суралцагчид санхүүжилт олгож болно.

Долоо. Хүний нөөц

- 7.1. Ажиллагсдын хөдөлмөрийн харилцааг Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Боловсролын тухай багц хуулиуд, ШУТИС-ийн дүрэм, Хөдөлмөрийн дотоод журам, холбогдох бусад хууль, эрх зүйн актаар зохицуулна.



Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн
Удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 17
өдрийн 02 дугаар тогтоолын хавсралт

- 7.2. Багш, ажилтны албан тушаалын ангилал, зэрэглэл, цалингийн сүлжээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн ШУТИС-ийн Ректор, харьяаллын байгууллагын захирлын тушаалаар батална.
- 7.3. Багш нь тухайн албан тушаалын тодорхойлолтод хамаарах ажил үүргийг гүйцэтгэх удирдлага буюу түүний эрх олгосон этгээдтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр гүйцэтгэнэ. Уг гэрээнд тухайн ажил үүргийг гүйцэтгэхэд шаардагдах нөхцөл, ажлын цаг, олгох цалин хөлс, давхар, нэмэлт болон сургуулиас гадуур ажил эрхлэх зохицуулалт, хариуцах эд хөрөнгө, хүлээх хариуцлага, тусгай шаардлага, ёс зүйн хэм хэмжээ зэргийг холбогдох хууль тогтоомжийн дагуу тодорхой тусгасан байна.
- 7.4. Хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэх удирдлагын баталсан холбогдох журмын дагуу багш, ажилтныг сонгон шалгаруулах, томилох, чөлөөлөх үйл ажиллагаа нь зохион байгуулагдана.
- 7.5. ШУТИС-ийн багш нь тухайн салбараар мэргэшсэн, тодорхой чиглэлээр судалгаа явуулдаг, дээд боловсролын салбарт багшлах бол магистр ба түүнээс дээш зэрэгтэй байна. Ахисан түвшний сургалтад оролцох багш нь докторын зэрэгтэй байна.
- 7.6. Багш, ажилтнууд нь сургалт, судалгаа шинжилгээ, үйлчилгээний ажлыг хэвийн явуулах нөхцөлөөр хангагдсан байх ба харилцааны соёл, ёс суртахуун, мэргэжлийн өндөр ур чадвартай, мэдлэг боловсролоороо манлайлагч байна.
- 7.7. Багш нь Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйл, Дээд боловсролын тухай хуулийн 16 дугаар зүйл, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан эрх, үүрэгтэй байна.
- 7.8. Багш, ажилтан Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлд заагдсан нийгмийн баталгаагаар хангагдана.
- 7.9. ШУТИС нь багшийн мэргэжлийн хөгжлийг хангах журмыг баталж, хэрэгжүүлнэ.
- 7.10. Багш, ажилтны гүйцэтгэх үүрэг, сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, олон нийтэд үйлчлэх ажлын ачаалал, түүнийг тооцох журмыг ШУТИС-ийн Ректор, харьяаллын байгууллагын Захирлын тушаалаар батална.
- 7.11. ШУТИС нь багш, ажилтны ажлыг үнэлж дүгнэх журамтай байна. Энэхүү журамд багш, ажилтны ажлыг дүгнэх шалгуур, үзүүлэлтүүд, дүгнэх хугацаа, зохион байгуулалтыг тодорхой тусгасан байна.

Найм. ШУТИС-ийн суралцагч

- 8.1. Суралцагч Боловсролын ерөнхий хуулийн 10 дугаар зүйл, Дээд боловсролын тухай хуулийн 13 дугаар зүйл, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.
- 8.2. Сургууль, суралцагчийн харилцааг тэдгээрийн хооронд байгуулсан гэрээ, сургуулийн дүрэм, дотоод журмаар зохицуулна. Суралцагч нь суралцах эрхийн гэрээг бүрэлдэхүүн, салбар, харьяа сургуулийн захиралтай байгуулах ба гэрээнд заагдсан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
- 8.3. Суралцагчдын элсэх, суралцах, шатлан суралцах, төгсөхөд тавигдах шаардлага, эдгээр үйл ажиллагааны харилцааг холбогдох дүрэм, журмаар зохицуулна.
- 8.4. Суралцагч нь сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд заасан сургалтын бүх хэлбэрийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, хөтөлбөрт заасан хичээлүүдийг судлах, тогтоосон хугацаанд шалгалт өгч сургалтын бусад даалгаврыг гүйцэтгэх, сургалтын төлбөрийг төлөх үүрэгтэй.
- 8.5. Суралцагч нь окутны холбоо, окутны зөвлөл болон бусад төлөөллийн байгууллагаараа дамжуулан их сургуулийн шийдвэр гаргах үйл явцад оролцох, санал бодлоо илэрхийлэх замаар нийтлэг эрх ашгаа хамгаалуулах эрхтэй.
- 8.6. Суралцагч нь суралцах, судалгааны ажил хийх таатай боломж нөхцөлөөр хангагдах, өөрийгөө хөгжүүлэх, нийгэм, соёлын үйлчилгээ авах эрхтэй.



Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн
Удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 17
өдрийн 02 дугаар тогтоолын хавсралт

- 8.7. Суралцагчид нь их сургуульд баримталж буй хууль, дүрэм журмыг дээдлэн, багш, шавийн харилцааг хүндэтгэх ба суралцах чин эрмэлзэл, бүтээлч санаачилга, өндөр соёл, ёс суртахуунтай байна.

Ес. ШУТИС-ийн багш, ажилтан, оюутан сайн дурын үүсгэл санаачилгын байгууллага

- 9.1. ШУТИС-ийн багш, ажилтан, оюутан суралцагч, төгсөгчийн хууль ёсны эрх, ашиг, сонирхлыг хамгаалах, сургуулийн хөгжлийг дэмжих, хамтран ажиллах зорилго бүхий ШУТИС-ийн багш, ажилтан, оюутан, төгсөгчдийн сайн дурын үүсгэл санаачилгын байгууллага, зөвлөлийг ШУТИС-ийн захиргааны болон багш ажилтан, оюутан суралцагч, төгсөгчдийн санаачилгаар хамтран зохион байгуулан ажиллуулж болно.
- 9.2. ШУТИС-ийн багш, ажилтан, оюутан төгсөгчдийн сайн дурын үүсгэл санаачилгын байгууллагын тэргүүн, дарга нарыг тухайн байгууллагын дүрмийн дагуу сонгоно.
- 9.3. ШУТИС-ийн багш, ажиллагчид, оюутан, төгсөгчдийн сайн дурын үүсгэл санаачилгын байгууллагууд нь Монгол улсын холбогдох хууль, тогтоомж, ШУТИС-ийн дүрэм, журмын хүрээнд үйл ажиллагаа явуулна.
- 9.4. ШУТИС-д оюутан суралцагчдын эрх ашгийг хамгаалах, мэргэжлийн үйл ажиллагаа, соёл, олон нийтийн арга хэмжээ, зохион байгуулах үүрэг бүхий сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдсэн оюутны байгууллага өөрийн удирдлагын зарчимд тулгуурлан ажиллаж болно.
- 9.5. ШУТИС-ийн оюутны байгууллага нь зөвхөн ШУТИС-ийн оюутан, суралцагчдын төлөөллөөс бүрдэх ба хууль тогтоомжид нийцсэн үйл ажиллагааны журмыг батлан мөрдөнө.
- 9.6. ШУТИС-ийн багш, ажилтан, оюутан, төгсөгчдийн сайн дурын үүсгэл санаачилгын байгууллагуудаар их сургуулийн үйл ажиллагааны зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж, холбогдох үйл ажиллагаанд нь санхүүгийн дэмжлэг үзүүлж болно.

Арав. Санхүүжилт

- 10.1. ШУТИС-ийн санхүүгийн үйл ажиллагааг Боловсролын тухай хуулийн 37, 38 дугаар зүйл, Дээд боловсролын тухай хуулийн 32, 33 дугаар зүйл, бусад холбогдох хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан их сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн дүрэм, журмыг баримтлан хэрэгжүүлнэ.
- 10.2. ШУТИС нь улсын төсвийн болон их сургуулийн үйл ажиллагаанаас оруулсан хөрөнгийг үүсгэн байгуулагчтай байгуулсан гэрээ, Удирдах зөвлөлийн шийдвэрийн дагуу үр ашигтай зарцуулах үүрэгтэй.
- 10.3. Санхүүгийн олон талт эх үүсвэрээ нэмэгдүүлэх, инновац, гарааны бизнесийг хөгжүүлэх, багш, ажилтан, суралцагчдын нийгмийн баталгааг дээшлүүлэх зорилгоор хууль тогтоомжид нийцүүлэн явуулсан аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлогоо Боловсролын тухай, Дээд боловсролын тухай, Инновацийн тухай хууль болон бусад холбогдох хууль, журамд заасны дагуу захиран зарцуулна.
- 10.4. ШУТИС-ийн санхүүжилт нь Боловсролын тухай хуулийн 37, 38 дугаар зүйл, Дээд боловсролын тухай хуулийн 32 дугаар зүйлд заасан санхүүгийн эх үүсвэрээс бүрдэнэ.
- 10.5. Тухайн жилийн батлагдсан төсөвт хөрөнгийн бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалтад хяналт тавих ажлыг холбогдох чиг үүрэг бүхий албан тушаалтан хариуцна.
- 10.6. ШУТИС-ийн дараа оны орлого, зарлагын төсвийг өмнөх оны 12 дугаар сарын 15-ны дотор Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулна.



Шинжлэх ухаан технологийн их сургуулийн
Удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 17
өдрийн 02 дугаар тогтоолын хавсралт

- 10.7. ШУТИС-ийн бүрэлдэхүүн, салбар, харьяаллын байгууллага, ШУТИС-ийн өмчийн оролцоотой бусад хуулийн этгээд нь жилийн тайлан, дараа жилийн тайлан, балансыг санхүүгийн асуудал эрхэлсэн нэгжид дараа жилийн 02 дугаар сарын 10-ны дотор багтаан хүргүүлнэ.
- 10.8. ШУТИС-ийн бүрэлдэхүүн, салбар, харьяаллын байгууллага, ШУТИС-ийн өмчийн оролцоотой бусад хуулийн этгээд нь хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг Төсвийн тухай хууль, санхүүгийн холбогдох журамд заасан хугацаанд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох бусад дээд байгууллагуудад хүргүүлнэ.
- 10.9. ШУТИС-ийн харьяа сургууль нь Боловсролын ерөнхий хуульд заасны дагуу санхүүгийн үйл ажиллагааг зохион байгуулан, харьяалах Удирдах зөвлөл, Сургуулийн зөвлөлд тайлагнана.
- 10.10. Сургалтын бус, эрдэм шинжилгээ, судалгаа инновац болон бусад чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг ШУТИС-ийн харьяаллын байгууллага нь холбогдох хууль, журамд заасны дагуу санхүүгийн үйл ажиллагааг зохион байгуулан, өөрийн удирдлагын байгууллагад тайлагнана.

Арван нэг. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах ба хүчин төгөлдөр болох

- 11.1. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Удирдах зөвлөл, Эрдмийн зөвлөл болон ШУТИС-ийн Ректорын зөвлөлийн гишүүд, багш, оюутны төлөөллийн байгууллага гаргаж болно.
- 11.2. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж батлах бөгөөд баталсан тухай шийдвэр гарснаар хүчин төгөлдөр болно.

---oOo---



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

“Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрэм” батлах тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1, Дээд боловсролын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.4 Боловсрол, шинжлэх ухаан ухааны сайдын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/576 дугаар тушаалаар батлагдсан "Дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн нийтлэг дүрэм", Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн "Удирдах зөвлөлийн дүрэм"-ийг хавсралтаар баталсугай.
2. "Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн "Удирдах зөвлөлийн дүрэм"-ийг мөрдөж ажиллахыг зөвлөлийн гишүүдэд, биелэлтийг хангаж ажиллахыг Удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад тус тус даалгасугай.
3. "Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн "Удирдах зөвлөлийн дүрэм" батлагдсантай холбогдуулан Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 02 тоот тогтоолоор баталсан "Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрэм"-ийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



М.БАТГЭРЭЛ



Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн
Удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 17
өдрийн 03 дугаар тогтоолын хавсралт

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Шинжлэх ухаан, технологийн их сургууль /цаашид ШУТИС гэх/ нь эцсийн өмчлөгч буюу үүсгэн байгуулагч, тухайн сургуулийн багш, суралцагч, төгсөгч, ажил олгогчийн төлөөллөөс бүрдсэн Удирдах зөвлөлтэй байна.
- 1.2. Удирдах зөвлөл нь ШУТИС-ийн өөрийн удирдлагыг хэрэгжүүлж, их сургуулийг хөгжүүлэх бодлого, стратегийг тодорхойлох, үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, түүний хэрэгжилтэд хяналт тавих, үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, дэмжлэг туслалцаа үзүүлэхэд оршино.
- 1.3. Удирдах зөвлөл нь Монгол улсын үндсэн хууль, Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Шинжлэх ухаан технологийн тухай хууль, Инновацийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, энэхүү дүрмийг үйл ажиллагаандаа баримтална.
- 1.4. Удирдах зөвлөл нь хууль ёсыг сахин дээдлэх, эрх тэгш, хариуцлагатай хамтран ажиллах, үйл ажиллагаандаа нээлттэй, ил тод байх, олон талын оролцоог хангах зарчмыг мөрдлөг болгоно.

Хоёр. Удирдах зөвлөлийн бүтэц зохион байгуулалт

- 2.1. Удирдах зөвлөл нь дарга, дэд дарга, гишүүдээс бүрдсэн 15 хүний бүрэлдэхүүнтэй байна.
- 2.2. Удирдах зөвлөлд үүсгэн байгуулагчийн төлөөлөл найм, багшийн төлөөлөл гурав, төгсөгч, ажил олгогчийн төлөөлөл гурав, суралцагчийн төлөөлөл нэг байна.
- 2.3. ШУТИС-ийн удирдах зөвлөлийн үүсгэн байгуулагчийн төлөөллийг Монгол улсын Засгийн газар буюу Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр томилно.
- 2.4. Удирдах зөвлөл дэх багшийн төлөөллийг ШУТИС-ийн бүрэлдэхүүн, салбар сургууль тус бүрийн нийт багш нарын 50-иас доошгүй хувийн ирцтэй хурлаас нэр дэвшүүлсэн төлөөллөөс Сонгох хороогоор дамжуулан сонгоно.
- 2.5. Сонгох хорооны бүрэлдэхүүн, үйл ажиллагааны удирдамжийг ШУТИС-ийн Ректорын тушаалаар батална.
- 2.6. Удирдах зөвлөлийн багшийн төлөөллийн нэг нь ШУТИС-ийн үйлдвэрчний эвлэлийн нэгдсэн хорооны төлөөлөл байх бөгөөд төлөөлөх байгууллагын хурлаас сонгогдоно.



Шинжлэх ухаан технологийн их сургуулийн
Удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 17
өдрийн 03 дугаар тогтоолын хавсралт

2.7. ШУТИС-ийн удирдах зөвлөл дэх суралцагч, төгсөгч, ажил олгогчийн төлөөллийг тэдгээрийг төлөөлөх байгууллагын хурлаар тус тус сонгоно.

Гурав. Удирдах зөвлөлийн даргыг сонгох, гишүүнээр ажиллах, гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болгох, эгүүлэн татах үйл ажиллагаа

- 3.1. Удирдах зөвлөлийн дарга, дэд даргыг нийт гишүүдийн 51-ээс дээш хувийн саналаар сонгоно. Удирдах зөвлөлийн даргыг сонгоход үүсгэн байгуулагч санал өгч болно.
- 3.2. Удирдах зөвлөлийн гишүүнээр удирдан манлайлах чадвартай, ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй хүнийг гурван жилийн хугацаагаар томилох буюу сонгоно.
- 3.3. Удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь ШУТИС-ийн захиргааны холбогдох нэгжийн удирдлага байна. Нарийн бичгийн даргыг ШУТИС-ийн Ректортой зөвшилцөн, удирдах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн томилно. Нарийн бичгийн дарга нь удирдах зөвлөлийн хуралд саналын эрхгүй оролцоно.
- 3.4. Доор дурдсан тохиолдолд удирдах зөвлөлийн дарга, гишүүнээс хугацаанаас нь өмнө чөлөөлнө:
 - 3.4.1. өөрийн хүсэлтээр;
 - 3.4.2. үүсгэн байгуулагчийн шийдвэрээр;
 - 3.4.3. өвчний улмаас болон бусад хүндэтгэх шалтгаанаар үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон.
- 3.5. Доор дурдсан тохиолдолд удирдах зөвлөлийн дарга, гишүүнээс хугацаанаас нь өмнө эгүүлэн татна:
 - 3.5.1. ёс зүйн зөрчил гаргасан нь эрх бүхий этгээдийн дүгнэлт, шийдвэрээр тогтоогдсон;
 - 3.5.2. удирдах зөвлөлийн дарга, гишүүн "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-г зөрчсөн нь тогтоогдсон.
- 3.6. Энэхүү дүрмийн 3.4, 3.5-д заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн болон эгүүлэн татагдсан гишүүнийг энэ дүрмийн 2.3, 2.4, 2.6, 2.7-т заасны дагуу нөхөн томилох буюу сонгоно.
- 3.7. Энэхүү дүрмийн 3.4, 3.5-д заасны дагуу чөлөөлөгдсөн, эгүүлэн татагдсан дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа өмнөх гишүүний бүрэн эрхийн хугацааны үлдсэн хугацаатай адил байна.
- 3.8. Удирдах зөвлөлийн дарга, гишүүн тухайн жилд удирдах зөвлөлийн хуралд хоёроос дээш удаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй тохиолдолд томилсон, сонгосон этгээд удирдах зөвлөлөөс эгүүлэн татаж болно.

Дөрөв. Удирдах зөвлөлийн үйл ажиллагаа



Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн
Удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 17
өдрийн 03 дугаар тогтоолын хавсралт

- 4.1. Удирдах зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
- 4.1.1. холбогдох хууль тогтоомжид заасны дагуу их сургуулийг хөгжүүлэх урт, дунд, богино хугацааны бодлого, төлөвлөгөө, дүрэм, журам, хөтөлбөрийг батлах, еерчлөх;
 - 4.1.2. их сургуулийн бүтэц, зохион байгуулалт, хөрөнгө оруулалт, тухайн жилийн төсөвийг баталж, зарцуулалтад хяналт тавих;
 - 4.1.3. аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс хандив, тусламж авах журам тогтоох, зарцуулалтад хяналт тавих;
 - 4.1.4. сургалтын төлбөр, оюутны үйлчилгээний зардал, дотуур байрны үйлчилгээний төлбөрийн хэмжээг зохих журмын дагуу төрөөс хараат бусаар тогтоох;
 - 4.1.5. оюутан элсүүлэх элсэлтийн хяналтын тоог батлах;
 - 4.1.6. их сургуулийн үйл ажиллагааны тайлан хэлэлцэх, үнэлэлт, дүгнэлт өгөх;
 - 4.1.7. удирдах зөвлөлийн үйл ажиллагааны жилийн тайлан, их сургуулийн үйл ажиллагааны тайланд хийсэн дүгнэлтийг үүсгэн байгуулагчид танилцуулах;
 - 4.1.8. нээлттэй сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн ШУТИС-ийн Ректорыг 5 жилийн хугацаагаар томилж, гэрээ байгуулах, хуульд заасан үндэслэлээр чөлөөлөх;
 - 4.1.9. ШУТИС-ийн Ректорын ажлын үр дүнг үнэлэх, гэрээ дүгнэх журмыг батлах, еерчлөх;
 - 4.1.10. ШУТИС-ийн Ректорын гэрээг жил бүр дүгнэж, үр дүнд үндэслэн сунгах эсэхийг шийдвэрлэх;
 - 4.1.11. дээд боловсролын үндэсний зөвлөлөөс гаргасан зөвлөмж, шийдвэрийг хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнах.
- 4.2. Удирдах зөвлөл нь үйл ажиллагаандаа туслах үүрэг бүхий орон тооны бус ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно
- 4.3. Удирдах зөвлөл Боловсролын ерөнхий хуулийн 33.2-т заасан шаардлагыг баримтлан ШУТИС-ийн Ректорын албан тушаалын (ажлын байрны) тодорхойлолтыг батална.
- 4.4. Удирдах зөвлөлийн дарга, гишүүн "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-д заасны дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг тухай бүр гаргана.
- 4.5. Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байна. Хуралд нийт гишүүдийн 60-аас доошгүй хувийн ирцтэй байх тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцож, хэлэлцсэн асуудлаар олонхын саналаар шийдвэр /тогтоол/ гаргаж, тэмдэглэл хөтөлнө. Удирдах зөвлөлийн дарга тогтоолд гарын үсэг зурж, сургуулийн тамга дарж баталгаажуулна.
- 4.6. Удирдах зөвлөлийн ээлжит хурлыг жилд хоёроос доошгүй удаа зохион байгуулна. Ээлжит бус хурлыг үүсгэн байгуулагч, удирдах зөвлөлийн дарга болон гурваас доошгүй гишүүний саналаар хуралдуулж болно.
- 4.7. Хүндэтгэх шалтгаанаар оролцох хуралд боломжгүй гишүүн хэлэлцэж шийдвэрлэх асуудлын талаарх саналаа урьдчилан бичгээр буюу цахим шуудангаар өгч болох бөгөөд энэ тохиолдолд хуралд оролцсонд тооцно.



Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн
Удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 17
өдрийн 03 дугаар тогтоолын хавсралт

- 4.8. Хүндэтгэх шалтгаанаар оролцох хуралд биеэр оролцох боломжгүй гишүүн зайнаас цахимаар оролцож болох бөгөөд энэ тохиолдолд хуралд оролцуулах техникийн нөхцөлийг хангасан байна.
- 4.9. Удирдах зөвлөлийн дарга удирдах зөвлөлийн хурлыг хурал болохоос ажлын гурваас доошгүй хоногийн өмнө товлон. Удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга тухайн хуралд хэлэлцэн шийдвэрлэх асуудалтай холбогдох материалыг гишүүдэд цахим шуудангаар, эсвэл хэвлэмэл байдлаар хүргүүлнэ.
- 4.10. ШУТИС-ийн ректор, проректор, холбогдох нэгжийн удирдлага, харьяалах байгууллагын захирал болон багш, ажилтан, суралцагчийн төлөөллийг удирдах зөвлөлийн хуралдаанд оролцуулан хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан тайлбар, санал, хүсэлтийг авч болно.
- 4.11. Удирдах зөвлөлийн даргын эрх, үүрэг:
 - 4.11.1. удирдах зөвлөлийг хуралдуулах хугацаа, хэлэлцэх асуудлыг ШУТИС-ийн Ректортой тохиролцон хуралдуулах;
 - 4.11.2. удирдах зөвлөлийн хурлыг удирдах, гарсан шийдвэрийг батлах;
 - 4.11.3. удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;
 - 4.11.4. удирдах зөвлөлийн гишүүдийн хуралдааны ирц, оролцооны талаарх мэдээллийг томилсон буюу сонгосон байгууллагад мэдэгдэх;
 - 4.11.5. удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг даалгавар өгч, ажил үүргийн хуваарь гарган хариуцуулах, биелэлтийг хангуулах;
 - 4.11.6. удирдах зөвлөлөөс томилсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн, түүний ажлын чиглэлийг тогтоох, төлөвлөгөөг батлах, гүйцэтгэлд нь хяналт тавих;
 - 4.11.7. ШУТИС-ийн Ректорын болон их сургуулийн үйл ажиллагаанд чиглэл өгөх;
 - 4.11.8. үүсгэн байгуулагчийн бодлого, шийдвэрийг тайлбарлах, сурталчлах ажлыг зохион байгуулах;
 - 4.11.9. Боловсролын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүнээс шилжүүлсэн эрх, бусад хууль, тогтоомж, журмын хүрээнд их сургуулийн Ректортой холбогдох асуудлаар (албан томилолтоор ажиллуулах, ажлын чөлөө, эзлжийн амралт олгох болон бусад) шийдвэр, тушаал гаргах.
- 4.12. Удирдах зөвлөлийн гишүүний эрх, үүрэг:
 - 4.12.1. удирдах зөвлөлийн хуралд оролцож, хэлэлцүүлж буй асуудалтай холбогдуулан санал хэлэх, асуудал хэлэлцүүлэх;
 - 4.12.2. ашиг сонирхлын зөрчилтэй гэдгийг илэрхийлэн тухайн асуудал хэлэлцэхэд оролцохоос татгалзах;
 - 4.12.3. удирдах зөвлөлийн хурлын дэгийг баримтлах;
 - 4.12.4. удирдах зөвлөлийн шийдвэр болон даргын өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь чанартай гүйцэтгэх, танилцуулах;
 - 4.12.5. их сургуулийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээлэл гаргуулах, боловсруулан гаргаж буй аливаа баримт бичиг, төсөл, төлөвлөгөө, тайлантай танилцах;
 - 4.12.6. удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор холбогдох хүмүүст шаардлага тавих, тайлбар гаргуулах;



Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн
Удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 17
өдрийн 03 дугаар тогтоолын хавсралт

- 4.12.7. их сургуулийн нэр хүндийг өсгөх, санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх ажилд идэвх санаачилгатай оролцох;
- 4.12.8. их сургуулийг хөгжүүлэх талаар гарсан бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх;
- 4.13. Удирдах зөвлөлийн дарга, гишүүн нь их сургуулийн сургалт, судалгааны үйл ажиллагаа (суралцагч элсүүлэх, суралцагчийн дүнг гаргуулах, хөрөнгө оруулалтын хэлэлцээ хийх, гэрээ байгуулах, г.м)-нд хөндлөнгөөс нөлөөлөхгүй.

Тав. Бусад зүйл

- 5.1. Удирдах зөвлөл нь хуулийн этгээдийн эрхгүй.
- 5.2. Удирдах зөвлөл тогтоол, тэмдэглэлийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ. Удирдах зөвлөлийн албан бичигт их сургуулийн албан тамгыг хэрэглэнэ.
- 5.3. Удирдах зөвлөлийн үйл ажиллагаанд холбогдон гарах зардлыг их сургуулийн тухайн жилийн төсөвт тусган зарцуулна.
- 5.4. Энэхүү дүрмийн 5.3-т заасан зардлаас удирдах зөвлөлийн дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга, гишүүдэд зөвлөлийн үйл ажиллагаанд оролцсон ирц, оролцоонд тохирсон урамшууллыг олгоно.

---oOo---



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот


Элсэлтийн хяналтын тоо батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийн 4.1.5 заалт, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2024 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. 2024-2025 оны хичээлийн жилд Шинжлэх ухаан, технологийн их сургуульд элсүүлэх бакалавр оюутны элсэлтийн хяналтын тоог хавсралтаар баталсугай.

2. Элсэлтийн үйл ажиллагааг элсэлтийн хяналтын тоонд багтаан, зохих журмын дагуу зохион байгуулахыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Ректор (Т.Намнан)-д даалгасугай.

ДАРГА



М.БАТГЭРЭЛ

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн
Удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 17
өдрийн 04 дугаар тогтоолын хавсралт



ШУТИС-ИЙН БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРТ 2024-2025 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД СУРАЛЦАГЧ ЭЛСҮҮЛЭХ ХЯНАЛТЫН ТОО

Д/д	Индекс	Элсэлт авах хөтөлбөрийн нэр	Тэргүүлэх (Т), Эрэлттэй (Э)	Элсэлтийн хяналтын тоо (2024 - 2025)		
				Үндсэн	30+ (3)	Нийт
БАРИЛГА, АРХИТЕКТУРЫН СУРГУУЛЬ						
1	073104	Архитектур	Т	60		60
2	073204	Барилгын инженерчлэл	Т	200		200
3	073204	Барилгын инженерчлэл (Японы Нагаока технологийн их сургуультай хамтарсан 2.5+2 хөтөлбөр)	Т	10		10
4	073209	Барилгын материалын үйлдвэрлэлийн технологи	Т	60	20	80
5	073207	Усны барилга, байгууламж	Т	60	10	70
6	073210	Авто замын инженерчлэл	Т	60		60
7	071205	Хаягдал боловсруулах технологи	Т	30		30
8	073201	Усан хангамж, ариутгах татуургын инженерчлэл	Т	50		50
9	073202	Сантехникийн инженерчлэл	Э	50		50
10	073203	Халаалт, агаар сэлгэлт, кондиционер	Э	50		50
11	078808	Усны нөөц, усжуулалт	Т	30		30
12	073107	Хот ба бүс нутгийн төлөвлөлт	Т	30		30
Нийт				690	30	720
БИЗНЕСИЙН УДИРДЛАГА, ХҮМҮҮНЛЭГИЙН СУРГУУЛЬ						
13	041201	Санхүү, банк		90	20	110
14	041301	Бизнесийн удирдлага		50	20	70
15	041301	Бизнесийн удирдлага (БНСУ-ын Сөүлийн Шинжлэх ухаан технологийн үндэсний их сургуультай хамтарсан 2+2 хөтөлбөр)		30		30
16	041304	Хүний нөөцийн менежмент		50	25	75
17	041401	Маркетинг		50	30	80
18	031301	Сэтгэл судлал	Э	50		50
19	041305	Нийтийн удирдлага		30		30
20	041402	Олон нийттэй харилцах ажил		30		30
21	092301	Нийгмийн ажил	Э	30		30
22	041302	Үйлдвэрлэлийн менежмент		30		30
23	041303	Менежмент		30		30
24	101501	Аялал жуулчлал	Э	60		60
25	041601	Худалдаа		30		30

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн
Удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 17
өдрийн 04 дугаар тогтоолын хавсралт



26	048802	Бизнес шинжлэл, загварчлал		30		30
Нийт				590	95	685
ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН СУРГУУЛЬ						
27	072405	Өрөмдлөгийн инженерчлэл		25	15	40
28	072406	Газрын тосны инженерчлэл	T	30	15	45
29	072407	Газрын тос боловсруулах үйлдвэрийн инженерчлэл		30		30
30	053201	Геодези	T	35		35
31	053201	Геодези (БНХАУ-ын Шандуны Шинжлэх ухаан технологийн их сургуультай хамтарсан 2+2 хөтөлбөр)	T	25		25
32	073101	Газар зохион байгуулалт		25		25
33	053204	Геологи	T	30		30
34	053205	Гидрогеологи		25		25
35	053207	Геофизик		25		25
36	053209	Ашигт малтмалын эрэл, хайгуул		25		25
37	072401	Уул уурхайн ашиглалтын технологи	T	100		100
38	072401	Уул уурхайн ашиглалтын технологи (ХБНГУ-ын "Фрайбергийн уул уурхайн академи" техникийн их сургуультай хамтарсан 3+2 хөтөлбөр)	T	30		30
39	072402	Уул уурхайн геотехник		35		35
40	072403	Уул уурхайн маркшейдер		40		40
41	072404	Ашигт малтмалын баяжуулалтын технологи	T	40	15	55
42	072901	Уурхайн машин тоног төхөөрөмж		30	15	45
43	072902	Уурхайн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт		30		30
44	102201	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй	Э	40	20	60
45	058802	Инженер геологи, геотехник		25		25
46	072408	Хийн инженерчлэл	T	25	15	40
Нийт				670	95	765
ГАДААД ХЭЛНИЙ СУРГУУЛЬ						
47	023101	Гадаад хэлний орчуулга /англи хэл/		30		30
48	023101	Гадаад хэлний орчуулга /хятад хэл/		30		30
49	023101	Гадаад хэлний орчуулга /солонгос хэл/		30		30
50	023101	Гадаад хэлний орчуулга /япон хэл/		25		25
Нийт				115		115
МЕХАНИК, ТЭЭВРИЙН СУРГУУЛЬ						
51	071502	Металлурги, металлын технологи	T	30	10	40
52	071507	Машин үйлдвэрлэлийн технологи		30		30
53	071402	Үйлдвэрлэлийн автоматжуулалт	T	40	10	50



Шинжлэх ухаан технологийн их сургуулийн
Удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 17
өдрийн 04 дугаар тогтоолын хавсралт

54	071506	Барилгын материалын үйлдвэрлэлийн машин, тоног төхөөрөмжийн ашиглалт		30		30
55	073211	Барилга замын машин төхөөрөмж		30	10	40
56	071501	Механик инженерчлэл	T	120		120
57	071501	Механик инженерчлэл (БНСУ-ын Сүн чон хян их сургуультай хамтарсан 2+2 хөтөлбөр)	T	30		30
58	071501	Механик инженерчлэл (БНСУ-ын Ханбатын үндэсний их сургуультай хамтарсан 2+2 хөтөлбөр)	T	30		30
59	071501	Механик инженерчлэл (БНСУ-ын Сөүлийн Шинжлэх ухаан технологийн үндэсний их сургуультай хамтарсан 2+2 хөтөлбөр)	T	30		30
60	071501	Механик инженерчлэл (Японы Нагаока технологийн их сургуультай хамтарсан 2.5+2 хөтөлбөр)	T	30		30
61	071602	Машины электрон систем		40		40
62	078811	Соёлын биет өвийн хадгалалт, хамгаалалтын технологи (БНСУ-ын Гунжугийн үндэсний их сургуультай хамтарсан 3+1 хөтөлбөр)	Э	30		30
63	078811	Соёлын биет өвийн хадгалалт, хамгаалалтын технологи	Э	30	10	40
64	041308	Нийлүүлэлтийн сүлжээ, логистик	T	40	10	50
65	071601	Авто инженерчлэл		60	10	70
66	071603	Авто хөдөлгүүрийн механик инженерчлэл		30		30
67	071604	Нисэх техникийн механик	T	50		50
68	071605	Авионик	T	30	10	40
69	071606	Зүтгүүр, зүтгүүрийн аж ахуй		30		30
70	104103	Төмөр замын тээврийн удирдлага, зохион байгуулалт		30		30
Нийт				770	70	840
МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ						
71	061301	Компьютерын ухаан	T	45	5	50
72	061902	Хиймэл оюун ухаан	T	40		40
73	071405	Программ хангамжийн инженерчлэл	T	80	10	90
74	061201	Компьютерын сүлжээ		45		45
75	061202	Кибер аюулгүй байдал	T	70	10	80
76	061202	Кибер аюулгүй байдал (БНСУ-ын Сүн чон хян их сургуультай хамтарсан 2+2 хөтөлбөр)	T	40		40
77	061204	Өгөгдлийн ухаан	T	50	5	55
78	061303	Мэдээллийн систем		50	5	55
79	061304	Мэдээллийн технологи	T	80	10	90
80	071401	Электроникийн инженерчлэл	T	80		80
81	061203	Мультимедиа технологи		50		50
82	061901	IoT /Юмсын интернэт/ технологи	Э	50		50

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн
Удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 17
өдрийн 04 дугаар тогтоолын хавсралт



83	071407	Мэдээлэл холбооны сүлжээний инженерчлэл		50		50
84	071407	Мэдээлэл холбооны сүлжээний инженерчлэл (ОХУ-ын Мэдээлэл холбооны техникийн их сургуультай хамтарсан 2+2 хөтөлбөр)		15		15
85	071408	Утасгүй холбооны инженерчлэл	T	50	5	55
86	071408	Утасгүй холбооны инженерчлэл (ОХУ-ын Мэдээлэл холбооны техникийн их сургуультай хамтарсан 2+2 хөтөлбөр)	T	15		15
87	078806	Робот ба хиймэл оюун ухаан		40		40
Нийт				850	50	900
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ						
88	051102	Микробиологи		20		20
89	051202	Биотехнологи	T	20		20
90	072102	Хоол зүй, шим судлал	Э	20		20
91	072103	Хүнсний чанар, аюулгүй байдал	T	20		20
92	021105	График дизайн		30		30
93	021106	Анимейшн, мультимедиа дизайн	Э	50		50
94	021202	Хувцасны дизайн		30		30
95	021203	Үйлдвэрлэлийн дизайн	Э	30		30
96	021204	Интерьер дизайн		60		60
97	072303	Текстилийн инженерчлэл		20		20
98	082102	Ойн инженерчлэл		20		20
99	071508	Хүнсний үйлдвэрлэлийн машин тоног төхөөрөмж		20		20
100	071509	Хөнгөн үйлдвэрлэлийн машин тоног төхөөрөмж		20		20
101	072104	Хүнс үйлдвэрлэлийн технологи	Э	35		35
102	072105	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний технологи		25		25
103	072301	Хувцас үйлдвэрлэлийн технологи, загвар зохион бүтээлт	T	20		20
104	072302	Арьс боловсруулалт, үйлдвэрлэлийн технологи	T	20		20
105	072203	Хэвлэл, медиа үйлдвэрлэлийн технологи		20		20
106	072204	Мод боловсруулах үйлдвэрлэлийн технологи		20		20
Нийт				500		500
ХЭРЭГЛЭЭНИЙ ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ						
107	054201	Статистик	T	25		25
108	054201	Статистик (Герман хэлний сургалттай хөтөлбөр)		25		25
109	054201	Статистик (БНХАУ-ын Баруун Хойд Политехникийн их сургуультай хамтарсан 2+2 хөтөлбөр)		25		25



Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн
Удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 17
өдрийн 04 дугаар тогтоолын хавсралт

110	053303	Хэрэглээний физик	T	25		25
111	071201	Хүрээлэн буй орчны инженерчлэл	T	20		20
112	071201	Хүрээлэн буй орчны инженерчлэл (БНХАУ-ын Нанжины аж үйлдвэрийн их сургуультай хамтарсан 2+2 хөтөлбөр)	T	20		20
113	078801	Нано шинжлэх ухаан, инженерчлэл	T	25		25
114	071101	Химийн инженерчлэл	T	30		30
115	071101	Химийн инженерчлэл (БНХАУ-ын Баруун Хойд Политехникийн их сургуультай хамтарсан 2+2 хөтөлбөр)	T	25		25
116	071103	Химийн боловсруулалтын технологи		20		20
117	071104	Нүүрсний боловсруулалтын технологи	T	20		20
118	071105	Газрын тосны боловсруулалтын технологи	T	20		20
119	072201	Материал судлал, инженерчлэл	T	25		25
Нийт				305		305
ЭРЧИМ ХҮЧНИЙ СУРГУУЛЬ						
120	071301	Сэргээгдэх эрчим хүч	T	50		50
121	071301	Сэргээгдэх эрчим хүч (БНХАУ-ын Хойд Хятадын эрчим хүчний их сургуультай хамтарсан 2+2 хөтөлбөр)	T	30		30
122	071303	Дулааны цахилгаан станцын инженерчлэл		40		40
123	071305	Дулааны процессын автоматжуулалт		50		50
124	071303	Дулааны цахилгаан станцын инженерчлэл (БНХАУ-ын Хойд Хятадын эрчим хүчний их сургуультай хамтарсан 2+2 хөтөлбөр)		30		30
125	071306	Дулаан хангамжийн инженерчлэл		30		30
126	071308	Хөргөлтийн технологи ба кондиционерийн систем		20		20
127	071304	Цахилгаан системийн автоматжуулалт		90		90
128	078810	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт	T	30		30
129	078810	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт (БНХАУ-ын Шанхайн Шинжлэх ухаан технологийн их сургуультай хамтарсан 2+2 хөтөлбөр)	T	30		30
130	071309	Цахилгааны инженерчлэл	T	100		100
131	071310	Цахилгаан хангамж	T	60		60
132	071310	Цахилгаан хангамж (БНХАУ-ын Хойд Хятадын эрчим хүчний их сургуультай хамтарсан 2+2 хөтөлбөр)	T	30		30
133	078813	Цахилгаан электроник		30		30
Нийт				620		620
ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ						
134	041301	Бизнесийн удирдлага (ДаТС)		20		20



Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн
Удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 17
өдрийн 04 дугаар тогтоолын хавсралт

135	041303	Менежмент (ДаТС)		20		20
136	071502	Металлурги, металлын технологи (ДаТС)	Т	0	12	12
137	071507	Машин үйлдвэрлэлийн технологи (ДаТС)		15	12	27
138	071506	Барилгын материалын үйлдвэрлэлийн машин, тоног төхөөрөмжийн ашиглалт (ДаТС)		15	12	27
139	072103	Хүнсний чанар, аюулгүй байдал (ДаТС)	Т	15		15
140	072104	Хүнс үйлдвэрлэлийн технологи (ДаТС)	Э	15		15
141	072401	Уул уурхайн ашиглалтын технологи (ДаТС)	Т	40		40
142	073204	Барилгын инженерчлэл (ДаТС)	Т	40		40
143	073201	Усан хангамж, ариутгах татуургын инженерчлэл (ДаТС)	Т	15	12	27
144	073203	Халаалт, агаар сэлгэлт, кондиционер (ДаТС)	Э	15		15
145	073209	Барилгын материалын үйлдвэрлэлийн технологи (ДаТС)	Т	15	12	27
146	071303	Дулааны цахилгаан станцын инженерчлэл (ДаТС)		25		25
147	071309	Цахилгааны инженерчлэл (ДаТС)	Т	30		30
148	071405	Программ хангамжийн инженерчлэл (ДаТС)	Т	40		40
149	071304	Цахилгаан системийн автоматжуулалт (ДаТС)		20		20
150	072902	Уурхайн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт (ДаТС)		15		15
151	061202	Кибер аюулгүй байдал (ДаТС, МХТС-ийн 2+2 хамтарсан хөтөлбөр)	Т	30		30
152	061303	Мэдээллийн систем (ДаТС, МХТС-ийн 2+2 хамтарсан хөтөлбөр)		30		30
153	071310	Цахилгаан хангамж (ДаТС, ЭХС-ийн 1+3 хамтарсан хөтөлбөр)	Т	15		15
154	071501	Механик инженерчлэл (ДаТС, МехТС-ийн 1+3 хөтөлбөр)	Т	15		15
155	073210	Авто замын инженерчлэл (ДаТС, БАС-ийн 1+3 хамтарсан хөтөлбөр)		15		15
156	072302	Арьс боловсруулалт, үйлдвэрлэлийн технологи (ДаТС, ҮТС-ийн 1+3 хамтарсан хөтөлбөр)		15		15
Нийт				475	60	535
Нийт дүн				5585	400	5985



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Сургалтын төлбөрийн нэг кредитийн үнэлгээ тогтоох тухай

Дээд боловсролын тухай хулийн 27 дугаар зүйлийн 27.1.4 дүгээр заалт, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дугаар заалт, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн бакалаврын сургалтад суралцагчдын сургалтын нэг кредитийн үнэлгээг хавсралтаар тогтоон мөрдсүгэй.

2. Дархан-Уул аймаг дахь технологийн сургуулийн (1+3) хамтарсан хөтөлбөрт суралцагчийн нэг кредитийн үнэлгээг тухайн хөтөлбөрийг харьяалах бүрэлдэхүүн сургуулиудын нэг кредитийн үнэлгээгээр тогтоон мөрдсүгэй.

3. Магистрантурын сургалтын нэг кредитийн үнэлгээг тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын нэг кредитийн үнэлгээг 1.4 коэффициентоор үржүүлж тогтоосугай.

4. Докторантурын сургалтын нэг кредитийн үнэлгээг тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын нэг кредитийн үнэлгээг 1.9 коэффициентоор үржүүлж тогтоосугай.

5. Бизнесийн ахисан түвшний сургуулийн сургалтын нэг кредитийн үнэлгээг Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн бакалаврын нэг кредитийн үнэлгээг 1.4 коэффициентоор, докторантурт 1.9 коэффициентоор, Инженерийн ахисан түвшний сургууль, Нээлттэй боловсролын төвийн сургалтын нэг кредитийн үнэлгээг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн бакалаврын сургалтын нэг кредитийн дундаж үнэлгээг магистрантурт 1.4, докторантурт 1.9 коэффициентоор үржүүлж тогтоосугай.

6. Цагийн сургалтаар элсэн суралцаж буй оюутны сургалтын нэг кредитийн үнэлгээг тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын нэг кредитийн үнэлгээг 1.2 коэффициентоор үржүүлж тогтоосугай.

7. Шинжлэх ухаан, технологийн их сургуульд хэрэгжүүлж буй гадаадын их, дээд сургуулиудтай хамтарсан хөтөлбөрийн хүрээнд гадаад хэл дээр заагдаж буй хичээлийн нэг кредитийн үнэлгээг тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын нэг кредитийн үнэлгээг 2.0 коэффициентоор үржүүлж тогтоосугай.

8. Шинжлэх ухаан, технологийн их сургуульд суралцах гадаад оюутны сургалтын нэг кредитийн үнэлгээг тооцохдоо энэхүү тогтоолын 1-5 дахь заалтуудад дурдсан сургалтын нэг кредитийн үнэлгээг 1.2 коэффициентээр үржүүлж тогтоосугай.

9. Шинжлэх ухаан технологийн их сургуулийн харьяа Ерөнхий боловсролын ахлах сургуульд 2024-2025 оны хичээлийн жилд шинээр элсэгчийн сургалтын төлбөрийг 4,500,000.0 (дөрвөн сая таван зуун мянган) төгрөгөөр, 2023-2024 оны хичээлийн жилд элссэн суралцагчийн сургалтын төлбөрийг 4,500,000.0 (дөрвөн сая таван зуун мянган) төгрөгөөр, өмнө онуудад элссэн суралцагчийн төлбөрийг 3,450,000.0 (гурван сая дөрвөн зуун тавин мянган) төгрөгөөр тус тус тогтоосугай

10. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Дарханы технологийн сургуулийн Ерөнхий боловсролын ахлах сургуульд 2024-2025 оны хичээлийн жилд мөрдөх сургалтын төлбөрийг 3,000,000.0 (гурван сая) төгрөгөөр тогтоосугай.

ДАРГА



М.БАТГЭРЭЛ



Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн
Удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 17
өдрийн 05 дугаар тогтоолын хавсралт

**ШУТИС-ИЙН 2024-2025 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД МӨРДӨХ СУРГАЛТЫН
ТӨЛБӨРИЙН НЭГ КРЕДИТИЙН ҮНЭЛГЭЭ**

Д.Д	СУРГУУЛЬ	Хөтөлбөрийн ангилал	Нэг кредитийн үнэлгээ төгрөгөөр			
			2024/25 оны хичээлийн жилд шинээр элсэгч	2023/24 оны хичээлийн жилд элссэн оюутан	2022/23 оны хичээлийн жилд элссэн оюутан	2020/21, 2021/22 оны хичээлийн жилд элссэн оюутан
1	БАРИЛГА, АРХИТЕКТУРЫН СУРГУУЛЬ	Инженер, технологи	170,000	157,000	147,000	112,000
2	ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН СУРГУУЛЬ		170,000	157,000	147,000	112,000
3	МЕХАНИК, ТЭЭВРИЙН СУРГУУЛЬ		170,000	157,000	147,000	112,000
4	МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ, ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ		170,000	157,000	147,000	112,000
5	ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ		170,000	157,000	147,000	112,000
6	ЭРЧИМ ХҮЧНИЙ СУРГУУЛЬ		170,000	157,000	147,000	112,000
7	ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ		170,000	157,000	147,000	112,000
8	БИЗНЕСИЙН УДИРДЛАГА, ХҮМҮҮНЛЭГИЙН СУРГУУЛЬ	Нийгмийн ухаан	166,000	154,000	143,000	109,000
9	ГАДААД ХЭЛНИЙ СУРГУУЛЬ	Хэрэглээний шинжлэх ухаан	148,000	137,000	128,000	98,000
10	ХЭРЭГЛЭЭНИЙ ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ		148,000	137,000	128,000	98,000
ШУТИС-ийн ДУНДАЖ			142,000			



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот


Оюутны байрны төлбөрийг тогтоох тухай

Дээд боловсролын тухай хуулийн 27.1.4 заалт, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 заалт, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

1. 2024-2025 оны хичээлийн жилд мөрдөх оюутын дотуур байрны төлбөрийг нэгдүгээр хавсралтаар, оюутны байранд амьдардаг айл өрхийн төлбөрийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Оюутны байрны орчин нөхцөлийг сайжруулах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Ректор (Т.Намнан)-д үүрэг болгосугай

ДАРГА



М.БАТГЭРЭЛ



Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн
 Удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 17
 өдрийн 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

2024-2025 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД МӨРДӨХ ОЮУТНЫ БАЙРНЫ ТӨЛБӨР

№	Оюутны байр	Өрөөний багтаамж, зориулалт	Сарын төлбөрийн хэмжээ мян төг	
			Нэг оюутан	Оюутнаас авах барьцаа (жилд)
1	Оюутны I байр (ХШУС)	4 хүний /дотоод оюутан/	83.5	30.0
		1 хүний люкс /гадаад оюутан, мэргэжилтэн/	267.5	30.0
		2 хүний люкс /гадаад оюутан, мэргэжилтэн/	237.5	30.0
		2 хүний энгийн /гадаад оюутан, мэргэжилтэн/	219.5	30.0
2	Оюутны III байр (БуХС)	2 хүний	98.5	30.0
		4 хүний	83.5	30.0
3	Оюутны IV байр (МХТС)	4 хүний	83.5	30.0
4	Оюутны V байр (МехТС)	4 хүний	83.5	30.0
5	ДаТС-ийн оюутны байр	4 хүний	73.5	30.0



Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн
Удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 17
өдрийн 06 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

2024-2025 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД МӨРДӨХ ОЮУТНЫ БАЙРАНД АМЬДАРДАГ АЙЛ, ӨРХИЙН ТӨЛБӨР

№	Оюутны байр	Өрөөний багтаамж /м2/	Нэг өрхийн сарын төлбөрийн хэмжээ (мян төг)				
			түрээс	цахилгаан	дулаан, халуун ус, цэвэр ус, бохир ус	хог	нийт төлбөр
1	Оюутны III байр (БуХС)	12	170.0	23.5	33.5	2.0	229.0
		18	188.0	23.5	33.5	2.0	247.0
2	Оюутны IV байр (МХТС)	18	120.0	23.5	33.5	2.0	179.0
		36	188.0	23.5	33.5	2.0	247.0
3	Оюутны V байр (МехТС)	9	108.0	23.5	33.5	2.0	167.0
		12	170.0	23.5	33.5	2.0	229.0
		18	188.0	23.5	33.5	2.0	247.0
		24	240.0	23.5	33.5	2.0	299.0



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн бүтэц батлах тухай

Дээд Боловсролын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2 заалт, Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 заалт, Дээд боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.8, 29 дүгээр зүйлийн 29.1 заалт, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 306 дугаар тогтоолын 1.1, 1.2, 1.3, 3 заалт, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 307 дугаар тогтоолын 2.2, 2.7 заалт, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн хурлын шийдвэр, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийн 4.1.2, 3.2 заалт, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн дүрмийн 3.8.2 заалт, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн бүтцийг хавсралтаар баталсугай.

2. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн бүтцэд өөрчлөлт орсонтой холбогдуулан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Ректор (Т.Намнан)-д даалгасугай.

ДАРГА



М.БАТГЭРЭЛ



Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн
Удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 17
өдрийн 07 дугаар тогтоолын хавсралт

